



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/122

Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах,  
нэмэлт өрчлөлт оруулах, хүчингүй болгох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дугаар тушаалыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах жагсаалтыг 1 дүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/287 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 2 дугаар багананд заасан "Байгууллагын нэр" гэсэн хэсгийн дотор "Голден фарм ХХК-ний Цаст-Уул эмийн сан" гэснийг "Задатын булаг ХХК-ний Цаст-Уул эмийн гэж, аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/189 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дугаар багананд заасан "Ажлын байрны хаяг" гэсэн хэсгийн Мөрөн сум 8-р баг, 16-3-27 гэснийг Мөрөн сум 8 дугаар баг, 13 дугаар байрны 3 тоот гэж, аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/474 дугаар захирамжийн "Эрхлэх үйл ажиллагааны чиглэл" гэсэн хэсгийн Лабораторийн тусламж үйлчилгээ (Клиник хими, биохими, гематолог, иммунологи) гэсэн хэсгийг Лабораторийн тусламж үйлчилгээ (Клиник хими, биохими, гематолог, иммунологи, нян судлал) гэж, аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/272 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 5 дугаар багананд заасан "Ажлын байрны хаяг" гэсэн хэсгийн Мөрөн сум 8 дугаар баг, ахуйн үйлчилгээний байр" гэснийг Мөрөн сум 7 дугаар баг "Баянцагаан" худалдаа үйлчилгээний төвийн 807 тоот гэж тус тус өөрчилсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Эрүүл мэндийн газрын (М.Үүрийнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн багц хууль, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудад холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 21-ны өдрийн  
А/12.2- дүгээр захирамжийн 1 дүгээр  
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
СУНГАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Энэрэх энэрэл" ХХК	Б.Хашчулуун	Эмийн сан	Мөрөн сум 3 дугаар баг 7-28 тоот	2022-04-21 2027-04-21

оОо

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 21-ны өдрийн  
А/1.2.2-дүгээр захирамжийн 2 дугаар  
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тайлбар
1	Олонд туслах ХХК –ний Олонд туслах эмнэлэг	П.Эрдэнэ-Очир	Уламжлалтын амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	Мөрөн сум 5-р баг “Олонд туслах” эмнэлгийн байр	“Олонд туслах” ХХК- ны албан хүсэлтээр цуцлах

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_